



ӨГҮҮЛЭХҮЙН ЭНТИМЕМИЙГ РАДИОГИЙН НЭВТРҮҮЛЭГЧИЙН УР ЧАДВАРТ АШИГЛАХ ОНЦЛОГ

Б.Цэвэлмаа*, Т.Өнөрсайхан*

**МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн докторант*

***МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны
тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D.)*

Түлхүүр үгс: радио, энтимем, нэвтрүүлэгч, контральто, вербаль сэтгүүл зүй

Өөрийн өвөрмөц илэрхийлэл болох “дуулдац”-аар хүрдэг радио сэтгүүл зүйд эн тэргүүнд аливаа мэдээллийг цээл тунгалаг хоолойгоор тод тогтуун өнгө аясаар цэгцтэй, ойлгомжтой, сонсголонтой ярих, уншиж хүргэх нь онцгой чухал юм. Радиогийн нэвтрүүлэгчийн хэлэхүй гэдэг бол бодит байдал, юмс үзэгдлийн тухай ерийн мэдээлэх төдий зүйл биш. Харин өгүүлж байгаа юмс үзэгдэл, хэрэг явдал, чанар шинж, нөхцөл байдалд хэрхэн хандаж байгаа сэтгүүлч, нэвтрүүлэгчийн байр суурь, мөн сонсогчид уг мэдээлэлд хэрхэн хандах боломжтойг давхар илэрхийлж байдаг объектив болон субъектив хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл, радиогийн энтимем нэвтрүүлэгчийн ур чадварыг илэрхийлээд зогсохгүй хүлээн авагч сонсогчийн сонирхлыг татах гол хэрэглэгдэхүүн болдог байна. Тус өгүүлэлд вербаль сэтгүүл зүйн гол объект болсон радиогийн нэвтрүүлэгчийн ур чадварт энтимемийн үзүүлэх нөлөөний талаар тайлбарлана.

Бидний амьдран байгаа мэдээллийн нийгэмд харилцааны асуудал тэргүүлэх чиглэл болж мэдээлэл солилцох, хүмүүсийн хооронд холбоо

тогтоох, хөгжүүлэх нарийн үйл явц нь хурд, шуурхай байдлаас хамаарч байна. Гэхдээ мэдээллийн энэ шуурхай чанар чухал боловч түүнийг хэрхэн, яаж хүргэж буй нь дутахааргүй ач холбогдолтой билээ. Радио бол хэвлэл мэдээллийн нэгэн хүчирхэг хэрэгсэл төдийгүй сонсохуйгаар дамжуулан хүрээлэн байгаа орчныг таньж мэдэх, улмаар сэтгэл оюундаа тухайн дүр, дүрслэлийг буй болгох боломж олгодог дуу авианы соёлын өвөрмөц үйлдвэрлэл. Нөгөө талаар сэтгүүл зүйд цагийн аясаар орж ирэн техникийн дэвшлийн үр дүнд бий болсон вербаль сэтгүүл зүй буюу ярьдаг сэтгүүл зүйн илэрхийлэл юм. Радиогийн хувьд хэд хэдэн онцлог шинж бий.

- Дуу авиа (яриа, авиа чимээ, хөгжим) бол илэрхийллийн гол арга болдог.
- Шууд яриагаар, ингэхдээ ямар нэгэн зүйлээр дамжуулан сонсогчидтойгоо харилцдаг.
- Сонсогчдын тусламжгүйгээр, холын зайнаас мэдээллийг хүргэдэг.
- Сонсогчид нэгэн зэрэг хүлээн авдаг.
- Нас хүйс, мэдлэг боловсрол ялгахгүйгээр тархдаг.
- Эфирийн өрөөнд амьдралыг бий болгодог. Энэ бүх чанараас шалтгаалан радио нь өөрийн гэсэн хэлний хэв маягтай (Дагиймаа, 2009) юм.

Радиогийн дүрслэлийн илэрхийлэмж олон хэв маягтай. Гэхдээ хөгжим, дүрс, чимээнээс эн тэргүүнд радиогийн өгүүлэхүй нь авиалбар-авиа, үгэлбэр-үг, хэлэхүй – хэлний энтимем онцлогоор тодорхойлогдоно. Зөв арга зүй үнэмшүүлэх аргатай хамаатай, харин үнэмшүүлэх арга бол нэг ёсны нотолгоо юм. Ийм болохоор уран илтгэхүй дэх нотолгоо бол энтимем мөн, харин энтимем бол ерөөсөө хэлэхэд үнэмшүүлэх аргуудын хамгийн чухал нь юм. Энтимем бол нэг ёсны силлогизм мөн (Аристотель, 2009) гэж Аристотель тодорхойлсон байдаг. Радио нэвтрүүлэгчийн үнэмшүүлэх арга зүй буюу энтимем, субъектив талыг өгүүлэхийн тулд объектив ур чадварыг юуны өмнө тайлбарлах шаардлагатай болно.

Радио сэтгүүл зүй хүний сонсголоор хүрдэг өвөрмөц онцлогтой дуун бүтээл юм. Радио мэдээллийн хэрэгсэл болгож байгаа эхний шинж нь дуулдаг. Дуулдцын нөлөөллийг хүний сонсголын эрхтэн бодит (объектив) болон хийсвэр (субъектив) байдлаар хүлээн авах үйл явц явагддаг. Иймд радио сэтгүүл зүйн шаардлагатай уялдаад радио техникийн үйл ажиллагааны зарчим зэрэгцэн яригдах ёстой болдог.

Дуун долгионы давтамжийг герцээр хэмждэг. Хүний нас, сонсголын онцлогоос хамааран 16 герцээс бага дуун долгион, 20 кигогерцээс дээш үелзлийг хүний сонсголын эрхтэн мэдэрдэггүй байна. Ер нь хүний яриа 100 герцээс 1000 герцийн үелзэлтэй байдаг. Радио сэтгүүл зүйд нэвтрүүлэгчийн цацруулагч дуун долгион өөрийн гэсэн онцлог өнгө, давтамж хүчтэй.

Эрэгтэй 100-150 герц, эмэгтэй 180-230 герцийн хоолой ихэнх хүнд таатай эвтэйхэн сонсогддог. Нэг секундэд үелзэл хэд байгаагаар нам, өндөр давтамжийг герцээр хэмжихээс гадна дууны хүч чанга сулыг децибелиэр хэмжин 85 децибелээс дээш бол стресс, сонсголын гэмтэлтэй холбоотой гэж үздэг. Иймд радиогийн нэвтрүүлэгчид тавигдах мэргэжлийн шаардлагын хамгийн эхний шалгуур нь дуу хоолойн зөв өнгө, хүч, цараа юм. Дууны цараа нэвтрүүлгийн утга санааг гаргах, дүрийг амилуулахад хамгийн чухал нөлөөтэй. Эрэгтэй нэвтрүүлэгч басс-аргил, баритон-баргил, тенор-цээл, эмэгтэй нэвтрүүлэгч сопрано-тунгалаг, контральто-эрдүү, дискант-цангинуур (Хишигээ, 1998) хоолой гэсэн хуваарилалттай байдаг. Эндээс баритон болон контральто хоолой нэвтрүүлэгчид хамгийн зохимжтой гэж үздэг. Ер нь радио техникийн тусламжтайгаар өнөө үед МҮОНР-ийн эмэгтэй нэвтрүүлэгч 256 герц, эрэгтэй нэвтрүүлэгч 182 герцийн давтамжаар уншиж байна.

Радиод нэвтрүүлэгчийн ур чадварыг эхний түвшинд сонсогчлод физиологийн хувьд хүлээн авахад зохимжтой байхаар ингэж тодорхойлдог бол дараагийн түвшинд үг үйлдэх урлал буюу хэл-хэлэхүй мэргэшлийн гол шаардлага болдог. Радио сэтгүүл зүйн хэлэхүй нь эх хэлнийхээ баялгийг эзэмших, үгсийн сангийн нөөц, уран сайхан хэллэг ашиглах талаар өвөрмөц давтагдашгүй шинж чанарыг түгээж байдаг.

Өөрөөр хэлбэл, радио нэвтрүүлэгчийн уран чадвар нь урлаг юм. Суут сэтгэгч Аристотель хэрэв шинжлэх ухаан угаас буй түгээмэл зайлшгүй юмыг учир зүйн нарийн чанд хэлбэрээр судалдаг бол урлаг “үнэхээр тохиолдсоныг биш, тохиолдож болох тэгэхлээр үнэмшилтэй буюу магадтайн үүднээс байж болох юмыг өгүүлдэг ажээ (Аристотель, 1969) гэсэн байдаг. Энэ үүднээс радио сэтгүүл зүй сэтгүүлч, нэвтрүүлэгч, найруулагч гурвын нийлмэл урлал юм. Нэвтрүүлэгчийн ур чадвараас радио нэвтрүүлгийн үр нөлөө шалтгаална. Иймд нэвтрүүлэгчийн уран чадварын үндэс нь өдөр тутмын уйгагүй бүтээлч ажиллагаа, бэлтгэл, хэл ярианы дасгал байдаг. Нэвтрүүлэгч ур чадвараа дээшлүүлэх талаар баримтлах тодорхой зарчимтай. Юуны тухай ярих унших, хэнд зориулж ярих хөтлөх, яах гэж ярьж байгаа гэсэн хэлэхүй буюу хүмүүсийн хоорондоо ярилцах ярианы энэ гурван зарчмыг мэдэж, баримталж чадвал аливаа нэвтрүүлгийг уншихад дөхөмтэй байдаг.

Нөгөө талаар радиогийн нэвтрүүлэгчийн онцлог нь “яг одоо” гэх нэг цаг хугацаанд, сонсогчийг дүрийн харилцаанд татан оруулж, тэдний төсөөллийг идэвхжүүлж чаддаг явдал юм. Ингэснээр радиогийн бүтээлийн утга санаа, үйл явдал кино дүрс шиг сэтгэлд бууж, сонсогчид хүргэх сонсох мэдээлэл үр өгөөжтэй болно. Дуулдац, хэлэхүйн чадвар нь нэвтрүүлэгчийн өдөр тутмын объектив хэрэглээ болдог бол радио энтимем түүнийг зөв гаргах

ур чадвар болж байдаг.

Энтимем хэмээх ойлголтыг анх системтэйгээр тодорхойлсон хүн бол Аристотель юм. Тэрээр “Уран илтгэхүйн ухаан” бүтээлдээ энтимемийг риторикийн үндсэн нотолгооны хэлбэр хэмээн тодорхойлж, энтимемийн гол шинж нь логик бүтцийн дутуу байдал бус, харин харилцааны нөхцөлд тохируулсан хэмнэлт юм. Өгүүлэгч нь сонсогч тухайн орхигдсон санааг өөрийн мэдлэг, туршлага, соёлын ойлголтоор нөхөж чадна. Уран илтгэхүйн ухаан бол тухайн юмс нэг бүрийн хувьд итгүүлэхийн боломжтой аргыг олох чадвар юм... зарим илтгэхүйн яриа жишээгээр дүүрэн байдаг, зарим нь энтимемээр хэрэглэхдээ дуртай. Жишээгээр дүүрсэн яриа багагүй итгүүлж чаддаг ч гэсэн энтимем ихтэй яриа илүү их сэтгэгдэл төрүүлдэг байна (Аристотель, 2009) гэж тодорхойлсон байдаг. Грек хэлний *энтимем* гэсэн үгийн гол утга нь ухаан дотор байгаа тэр зүйл бүрэн хэлээгүй байгаа логик нотолгоо гэсэн санаа юм.

Аристотель энтимемийг ерөнхий үнэнд тулгуурласан, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн итгэл үнэмшил дээр суурилсан, сонсогчийн оролцоог идэвхжүүлдэг гэж тодорхойлсон нь радиод онцгой тохирдог. Өөрөөр хэлбэл, хүний ярианд, эх бичвэрт эсвэл хоорондын харилцаанд зарим нь ойлгомжтой гэж үзэж байгаа учраас ил хэлээгүй, гэхдээ сонсогч түүнийг өөрөө нөхөж ойлгож чадна гэж тооцсон элементүүд орхигддог. Радиогийн нэвтрүүлэгчид сонсогчидтой шууд харилцаж, ойлгомжтой, итгэл төрүүлэхээр товч, шууд, тухайн үзэж буй сонсогчийн бодит ойлголттой нийцсэн логик хэлбэрээр мэдээлэл дамжуулдаг.

Радиогийн нэвтрүүлэгчийн ярианд энтимем өргөн хэрэглэгддэг нь эфирийн цагийн хязгаарлалт, сонсогчийн урьдчилсан мэдлэгт тулгуурласан харилцааны онцлогтой холбоотой. Орхигдсон логик үндэслэл нь сонсогчийн ухамсарт нөхөгдөх замаар итгэл төрүүлэх чанарыг нэмэгдүүлдэг байна. Нөгөө талаар, энтимем нь радиогийн нэвтрүүлэгчийн хувьд логик, сэтгэл зүйн, харилцааны гол тулгуур элемент юм. Ингэж Аристотелийн сонгодог онолоос эхтэй энтимем нь орчин үеийн радиод сонсогчийн оролцоонд суурилсан итгэл төрүүлэх хэлэхүйн хэлбэр болон хөгжсөн байна.

Радиод нэвтрүүлэгч ярихдаа ойлгомжтой, товч, сонсогчийн урьдчилсан мэдлэгт суурилсан, тодорхой нэг санааг шууд дэмжсэн, бодит үнэн мэт ойлгогддог энтимемийн техник ашигладаг. Энтимемийн практик ач холбогдлыг нэвтрүүлэгчийн өдөр тутмын үйл ажиллагаанаас харж болно. МҮОНР-ийн нэвтрүүлэгчдийн байнга ашигладаг энтимемийг жишээ болгон авч задалж үзье.

1. Мэдээллийн нэвтрүүлэг дэх энтимемийн жишээ.

- Нэвтрүүлэгч: *Энэ мэдээллийг бид албан эх сурвалжаас авсан тул бодитой гэж үзэж болно.*
- Дүгнэлт: Энэ мэдээлэл бодитой.
- Ил хэлэгдсэн үндэслэл: Албан эх сурвалжаас авсан
- Орхигдсон үндэслэл буюу энтимем: *Албан эх сурвалжаас авсан мэдээлэл үнэн байдаг.*

Энэхүү орхигдсон санаа нь монголын нийгэмд өргөн хүлээн зөвшөөрөгдсөн ойлголт тул нэвтрүүлэгч түүнийг тайлбарлах шаардлагагүй гэж үзжээ. Радио сонсогчид “албан эх сурвалж” гэх хэллэгийг найдвартай байдалтай шууд холбож ойлгодог. Энэ нь энтимемийн итгэл төрүүлэх байдлыг тод харуулж байна.

2. Нийгмийн сэдэвт нэвтрүүлэг дэх энтимемийн жишээ.

- Нэвтрүүлэгч: *“Энэ асуудал олон нийтийн анхаарлын төвд орсон, тиймээс шийдэл зайлшгүй шаардлагатай.”*
- Дүгнэлт: Шийдэл зайлшгүй шаардлагатай
- Ил хэлсэн үндэслэл: Олон нийт хариулт хүлээж байна
- Орхигдсон үндэслэл: *Олон нийтийн анхаарал татсан асуудлыг шийдэх ёстой*

Энд нэвтрүүлэгч ёс зүйн энтимем ашигласан байна. Өөрөөр хэлбэл, логик үндэслэл нь баримтаас илүү нийгмийн үнэт зүйлд тулгуурласан.

3. Ярилцлагын нэвтрүүлэг дэх энтимемийн жишээ.

- Нэвтрүүлэгч: *“Манай зочноор энэ салбарт олон жил ажилласан хүн оролцож байна.”*
- Дүгнэлт: Энэ зочинд итгэж болно
- Ил хэлэгдсэн үндэслэл: Олон жил ажилласан
- Орхигдсон үндэслэл: *Олон жил ажилласан хүн мэргэжлийн мэдлэгтэй байдаг.*

Энэхүү энтимем нь зочны нэр хүндийг баталгаажуулах үүрэгтэй. Радио нэвтрүүлэгч үүгээрээ сонсогчийг ярилцлагын агуулгыг шүүмжлэлгүй хүлээн авахад бэлтгэж байна.

4. Үнэлгээ, дүгнэлт бүхий эфирийн төгсгөл дэх энтимемийн жишээ.

- Нэвтрүүлэгч: *Энэ бол өнөөдрийн бодит байдал.*
- Дүгнэлт: Яригдсан зүйл үнэн
- Орхигдсон үндэслэл: *Бид бодит баримтад тулгуурлан ярьсан*

Энэ бол хамгийн богино, хамгийн хүчтэй энтимем. Радиод ийм хэлбэр их ашиглагддаг бөгөөд нэвтрүүлэгчийн итгэл үнэмшилтэй дуу хоолой

логик үндэслэлийг орлон гүйцэтгэдэг.

Дээрх жишээнээс нэгтгэн дүгнэхэд манай радиогийн нэвтрүүлэгчид энтимемийг тогтмол, санамсаргүй байдлаар ашигладаг байна. Тухайн цаг үе, нөхцөл байдалдаа тохируулан энтимемийн хэлбэрийг сонгож ингэхдээ орхигдсон үндэслэлүүд нь ихэнхдээ нийгмийн нийтлэг ойлголт, ёс зүй, мэргэжлийн нэр хүнд гэсэн түгээмэл хэдхэн хэлбэр дээр илэрч байна. Гэтэл энтимем нь сонсогчдод итгэл төрүүлэх, хэт урт сунжирсан ярианаас зайлсхийж цаг хэмнэх, сонсогчдыг өдөөж идэвхтэй байлгах үүргийг гүйцэтгэдэг онцлогтой. Урьдчилсан байдлаар энтимемийг бэлтгэх нь нэвтрүүлгийн үр өгөөж, сонсогчдод нөлөөлөх нөлөөллийг нэмэгдүүлдэг байна.

Орчин үед радио сэтгүүл зүй технолог, бүтэц тогтолцоо, хөтөлбөрийн бодлого чиглэл, нэвтрүүлгийн төрөл зүйлийн хувьд гээд бүх талаараа шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байна. Гэхдээ өөрчлөлт шинэчлэлтийг хэт макро орчны хүрээнд авч үзэж мэргэжлийн өдөр тутмын үйл ажиллагааг орхигдуулах нь тийм ч зүйтэй хандлага биш юм. Ямар ч хэвлэл мэдээллийн салбарт бүтээл буюу контент үйл ажиллагааны үндсэн гол цөм нь болдог. Хүлээн авагчид хэвлэл мэдээллийн байгууллага бус бүтээлийг сонгодог болсон энэ цаг үед бүтээлийг сайжруулах арга замыг бүх талаас эрэлхийлэх нь зүйтэй юм. Радио энтимемийг гүнзгийрүүлэн судалж, нэвтрүүлэгчийн ур чадварыг сайжруулах нь мэдээллийн үр нөлөөг нэмэгдүүлж, сонсогчдыг татах интерактив харилцааны үндэс суурь болно.

Эшлэл

- Дагиймаа Д. 2009. *Радио сэтгүүл зүйн үндэс*. УБ., х 65.
Аристотель. 2009. *Уран илтгэхүйн ухаан*. УБ., 15 х.
Хишгээ Б. 1998. *Микрофонтой харьцахад*. УБ.
Аристотель. 1969. “*Туурвилзүй*”. УБ., х 17.
Аристотель. 2009. *Уран илтгэхүйн ухаан*. УБ., 12х

Ашигласан бүтээлийн жагсаалт

- Аристотель. 1969. *Туурвил зүй*. УБ.
Аристотель. 2009. *Уран илтгэхүйн ухаан*. УБ.
Дагиймаа Д. 2009. *Радио сэтгүүл зүйн үндэс*. УБ.
Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2010. *Радио сэтгүүл зүйн үндэс*. УБ.
Хишгээ Б. 1998. *Микрофонтой харьцахад*. УБ.

Summary

The article discusses the radio enthymeme and impact on the skills of anchors. An enthymeme is an argument, or chain of argumentation, with one or more missing premises or conclusions. Radio anchors use enthymemes regularly and randomly: social common sense, ethics, and professional reputation.

Keywords: radio, enthymeme, anchor, contralto, verbal journalism